



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2022.06.13-2022.06.17

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.06.20-ны pre-trading session байдлаар

| АНУ | Ханш | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
|--------------------|-----------|----------|---------|---------|---------|
| US30 | 29,897.00 | 0.05% | -2.35% | -6.53% | -12.04% |
| US500 | 3,685.93 | 0.32% | -2.16% | -7.68% | -13.16% |
| NASDAQ | 11,369.00 | 0.93% | 0.11% | -6.10% | -20.07% |
| Европ | Ханш | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
| GB100 | 7,016.00 | -0.41% | -4.12% | -5.67% | -0.02% |
| DE40 | 13,126.00 | 0.67% | -4.62% | -6.29% | -15.03% |
| FR40 | 5,883.00 | -0.06% | -4.92% | -7.40% | -10.45% |
| IT40 | 21,789.00 | 0.29% | -3.36% | -9.54% | -13.60% |
| ES35 | 8,146.00 | 0.84% | -2.92% | -3.90% | -9.80% |
| Ази | Ханш | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
| JP225 | 25,578.00 | -1.50% | -5.13% | -5.18% | -8.60% |
| SHANGHAI | 3,316.00 | 0.00% | 1.80% | 5.32% | -6.09% |
| CSI 300 | 4,340.00 | 0.74% | 3.50% | 6.95% | -14.82% |
| SHANGHAI 50 | 2929.00 | -0.26% | 2.81% | 5.11% | -14.76% |
| CH50 | 14,277.00 | -0.05% | 3.47% | 6.58% | -16.62% |
| SENSEX | 51360.00 | -0.26% | -5.42% | -5.25% | -1.88% |
| Эрчим хүч | Ханш | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
| Газрын тос (Crude) | 109.22 | -0.43% | -9.76% | -1.05% | 49.41% |
| Газрын тос (Brent) | 112.70 | -0.36% | -7.79% | 1.77% | 50.61% |
| Байгалийн хий | 6.71 | -3.15% | -21.93% | -23.25% | 110.31% |
| Шатахуун | 3.77 | -0.64% | -6.68% | 2.33% | 71.79% |
| Нүүрс | 389.35 | -1.43% | -0.76% | -5.50% | 211.48% |
| Түүхий эд | Ханш | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
| Алт | 1844.14 | 0.26% | 1.40% | -0.48% | 3.44% |
| Мөнгө | 21.71 | 0.44% | 3.11% | -0.30% | -16.28% |
| Зэс | 4.00 | -0.32% | -4.96% | -7.74% | -4.30% |
| Бонд /10 жил/ | Өгөөж | Өөрчлөлт | 7 хоног | 1 Сар | 1 жил |
| АНУ | 3.2313 | 0.0361 | 0.07% | 0.35% | 1.79% |
| Англи | 2.5000 | 0.0170 | 0.06% | 0.63% | 1.75% |
| Швейцар | 1.3960 | 0.0850 | 0.25% | 0.68% | 1.61% |
| Испани | 2.7520 | 0.1270 | -0.02% | 0.65% | 2.30% |
| Португали | 2.7140 | 0.1220 | -0.08% | 0.56% | 2.28% |

Инфляц vs. Эдийн засаг: Шинжээчдийн өмнө таамаглаж байснаас юу өөрчлөгдөв?

Сүүлд гарсан инфляцын мэдээтэй холбоотойгоор эдийн засгийн нөхцөл байдал хурдтай муудлаа. Edward Jones-ийн шинжээчдийн үзэж байгаагаар АНУ-ын эдийн засаг дунд хугацаандаа саарах төлөвтэй байна. Тэдний ирээдүйг урьдчилж тооцоолсон моделиор нийлүүлэлтийн удаашрал болон газрын тосны ханш өндөр байгаа зэрэг нь эдийн засагт сөргөөр нөлөөлж байна гэж үзжээ. Харин нөгөө талаасаа ажил эрхлэлт, зээлийн нөхцөл байдал болоод компаниудын ашиг гэсэн хүчин зүйлс нь эдийн засгийг дэмжиж өгч байна.

5 сарын инфляцын мэдээ ХНСанг цаашид илүү хатуу мөнгөний бодлого баримтална гэсэн төсөөлөл үүсгэж байгаа тул эдийн засгийн нөхцөл байдал ойрын үед хүндхэн байхаар харагдаж байна. Хөрөнгийн зах зээл энэхүү өсөж буй бодлогын хүүд хэтэрхий хүчтэй хариу үйлдэл хийн уналт үзүүлсэн.

Зах зээлийн хураангуй:

- Геополитикийн асуудлаас үүдэлтэй газрын тос болон хоол, хүнсний үнэ өндөр байгаа нь инфляцын түвшинг өсгөсөөр байна.
- ХНС инфляцыг цаашид өсгөхгүйн тулд бодлогын хүүг хурдтай нэмж байна. Энэ нь Төв банкнаас болж эдийн засаг хямралд орчих вий гэсэн айдсыг улам өдөөж байна.
- Хөрөнгийн болон бондын зах зээл хоёрын төсөөлөл хамгийн муу түвшиндээ хүрч байх шиг байна. Edward Jones-ийн зүгээс үнэт цаасны зах зээлийг хөрөнгө оруулагчид бодит дүр зургаас хэтэрхий сөрөг болгож харж байна гэж үзжээ.

Шинжээчдийн өмнө таамаглаж байснаас юу өөрчлөгдөв?

1. Хөдөлмөрийн зах зээл: Ажлын байр нэмэгдэж байгаа боловч ажилгүйдлийн тэтгэмж авч буй хүмүүсийн тоо мөн нэмэгдэж байна

5 сард ажлын байрын өсөлт хангалттай сайн байжээ. Шинээр зарлагдсан ажлын байрны зарын тоо ажилгүй иргэдийн тооноос 2 дахин их байгаа нь хөдөлмөрийн зах зээл тогтвортой байгааг илтгэж байна. Эдийн засаг удахгүй хямралд орно гэсэн хүлээлт газар авч байгаа боловч ажилгүйдлийн түвшин 3.6% байгаа нь түүхэн доод хэмжээ юм. АНУ-ын хувьд ажилгүйдлийн түвшний сүүлийн 3 сарын дундаж 0.3%-иас дээш өссөн тохиолдолд эдийн засгийн хямралд орсон зүй тогтолтой ажээ.

Ажилгүйдлийн түвшин нь өнгөрснийг харуулсан хоцрогдолтой эдийн засгийн үзүүлэлт тул шинжээчид ажилгүйдлийн тэтгэмж авагчид болон төрийн ажилгүйдлийн даатгал авсан хүмүүсийн тоог илүү онцолж авч үздэг. Эдгээр үзүүлэлтүүд нь эдийн засгийн нөхцөл байдлыг ирээдүйд ямар байхыг тодорхойлсон илүү урьдчилж харсан байдаг. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо хэдий доогуур түвшинд байгаа ч 4 сараас хойш өсөх хандлагатай байгаа ба хамгийн доод хэмжээнээс одоогоор 20% өссөн үзүүлэлттэй байна. Эдийн засгийн уналттай үед компаниуд ашигт ажиллагаагаа хадгалахын тулд зарим ажилчдаа цөөлж цалингийн зардлаа танах үйлдэл хийж магадгүй.

АНУ-ын ажилгүйдлийн тэтгэмж авсан хүмүүсийн өсөлт



2. Инфляц: Түүхий эдийн ханш өсөлттэй байгаа нь юмны үнэ ханш өсөхөд нөлөөлж байна.

Энэ оны хагас гэхэд нийлүүлэлтийн гинжин хэлхээний асуудал шийдэгдэж суурь инфляцын түвшин (хоол, хүнс болон эрчим хүч ороогүй) буурна гэсэн төсөөлөлтэй байсан боловч бодит байдал дээр энэхүү бууралт хэтэрхий удаан байлаа.

Хөрөнгийн зах зээл болон ХНС суурь инфляцаас илүү нэрлэсэн инфляцад анхаарал хандуулж байна. Орос-Украины дайн болон БНХАУ-ын хөл хорио зэрэг урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлаас болж нэрлэсэн инфляцын түвшин өссөөр байна. Харамсалтай нь ХНС-ийн зүгээс бодлогын хүүг ихээр өсгөсөн ч газрын тос болон хүнсний нийлүүлэлтэд нөлөөлж чадахгүй тул өрхийн худалдан авалт буурч болзошгүй.

АНУ-ын инфляц




Эх сурвалж: Fred.com

Эх сурвалж: edwardjones.com

3. Урт болон богино хугацаат бондын өгөөжийн зөрүү багасаж (богино хугацаат бондын өгөөж өсөж, урт хугацаат бондын өгөөж буурч) байгаа нь эдийн засгийн өсөлт буурах дохио болж өгдөг

Инфляцын өсөлт таамаглаж байснаас удаан үргэлжилж байгаа болон ХНС бодлогын хүүг ойрын хэдэн сар нэмнэ гэсэн хүлээлт бондын зах зээлд хүчтэй нөлөөлж байна. Шинжээчдийн таамгаар 10 жилийн хугацаатай бондын өгөөж хамгийн ихдээ 3.5% хүрнэ гэж төсөөлсөн нь өнгөрсөн 7 хоногт 3.4% хүрсэн нь энэ түвшинд ойрхон байгаа ба цаашид ихээр өсөхгүй гэж харж байна. Бондын өгөөжийн ихэнх өсөлт аль хэдий нь болоод өнгөрсөн гэж харж байна.

АНУ-ын засгийн газрын үнэт цаасны зөрүү




4. Зардал өсөж байгаа нь аж ахуй нэгжүүдийн ашигт ажиллагаанд хүндрэл үзүүлж магадгүй.

Эхний улирлын санхүүгийн тайлан өсөлттэй гарсан нь компаниудын үнэлгээ буурч байгаагийн эсрэг дэмжлэг үзүүлж байна. Олны танил технологийн компаниудын ашиг таамаглаж байснаас доогуур гарсан ч нийт шинжээчдийн зүгээс S&P 500 компаниудын ашиг энэ жил 10.5%, дараа жил 9.2% өснө гэсэн таамаглалтай байна.

Цалин болон түүхий эд материалтай холбоотой зардлууд өсөж байгаа нь компаниудын ашгийн таамаглалыг бууруулах магадлалтай. Edward Jones-ийн шинжээчид өрхийн худалдан авалт тогтвортой байгаа тул компаниудын ашигт ажиллагааг өнгөрсөн жилийнхээс буурахгүй гэж харж байна.

АНУ-ын компаниудын ашиг өсөж байгаа боловч цаашид саарах төлөвтэй байна



Дээрх зураг үйлдвэрлэгчдийн индекс (PMI) болон компаниудын ашгийн өсөлт хоёрын зүй тогтлыг харуулав.

5. Худалдан авагчид болон хөрөнгө оруулагчдын хандлага муудсан

6 сарын Мишиган Их Сургуулийн Худалдан Авагчдын индекс түүхэн доод түвшинд хүрсэн нь инфляцаас үүдэлтэй худалдан авагчдын итгэх итгэл муудсаныг харуулж байна. Хэдий ажилгүйдлийн түвшин одоогоор бага байгаа ч цаашид ажлын байрны цомхотгол өсөж болзошгүй тул өрхийн худалдан авалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Өрхийн худалдан авалт АНУ-ын эдийн засгийн 70%-ийг эзэлдэг нь өрхийн орлого болон цаашдын хандлага эдийн засгийн хямрал болох эсэхэд ихээхэн нөлөөлөх боломжтой.

Хөрөнгө оруулагчдын хандлага хэдий муу байгаа ч энэ нь хөрөнгийн зах зээлийн ханш ёроолдоо хүрснийг урьдчилан мэдэгдэж байж болох юм. Хувьцаануудын өнөөгийн үнэ ашгийн харьцаа эдийн засгийн хямралтай үеийн түвшинд хүрсэн тул хөрөнгийн зах зээлийн уналт дуусах талдаа орж байгаагийн дохио байж болно.

Худалдан авагчдын итгэл бага үед хөрөнгийн зах зээл өсөлт үзүүлдэг



Дээрх зураг худалдан авалтын түвшин их унасны дараа хөрөнгийн зах зээл сэргэдэг зүй тогтлыг харуулав.

Хөрөнгө оруулагчдад өгөх зөвлөмж

Хөрөнгийн зах зээлийн томоохон уналтыг туулахад бэрх байдаг боловч, энэхүү бэрхшээлийг давж гарсан сэтгэлийн тэнхээтэй хөрөнгө оруулагчид эцэст нь хождог. Эдийн засгийн нөхцөл байдал хэдий муудаж, бүгд ирээдүйг муугаар төсөөлж байгаа боловч ийм л үеэс ёроол үүсэж өсөх тренддээ ордог.

Өсөлтийн хөдөлгөөн алгуурхан явагдахаас биш нэг цэгээс гэнэт өсчихгүй. Одоогийн байдлаар хөрөнгийн болон бондын зах зээл эдийн засгийн хямралыг аль хэдий нь тусгасан тул цаашид ихээр нэмж унахгүй болов уу. Шинжээчдийн үзэж байгаагаар инфляцын түвшин дараагийн хэдэн сараас тодорхой болсноор ХНС бодлогын хүүг нэмж өсгөхөө зогсоох эсэх нь мэдэгдэнэ.

Өнөөгийн хэлбэлзэлтэй үед урт хугацаандаа хэрхэн өгөөжтэй багц бүрдүүлэх вэ?

ХНС бодлогын хүүг хүчтэй өсгөсөнтэй холбоотойгоор хөрөнгийн зах зээл таамаглаж байснаас илүү уналттай байлаа. Гэвч Edward Jones-ийн шинжээчдийн үзэж байгаагаар сайн чанартай компанийн хувьцааг хямд байгаа дээр нь авч хөрөнгө оруулалт хийх нь бага үнэлгээтэй компанийн хувьцаа авахаас илүү оновчтой гэж үзжээ.